



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-19</i>

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	4-6
2.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 13 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-19

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 03-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Бейсен, С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил,
Б.Саранчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан;
Чөлөөтэй: Б.Баярсайхан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Анужин төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 13 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

П.Анужин: Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 1
Бүгд: 9
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, 17 гишүүнээс 9 гишүүн хуралцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 09 цаг 35 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

П.Анужин: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж. Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Одонтуяа гишүүн маань эмнэлэгт хэвтэж байгаа боловч сүүлийн Байнгын хорооны хуралдаанууд дээр бас үргэлж эмнэлгээсээ хүрэлцэн ирж асуудалд идэвхтэй оролцож байгаад баярлалаа. Маш үлгэр жишээч шилдэг гишүүн гэдгийг бас хэлье ээ. Сүүлийн одоо бүх Байнгын хорооны хуралдаан дээр эмнэлгээс ирж байгаа шүү. Баярлалаа танд.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэндээ танилцуулъя.

Булгантуяа сайд хүрэлцэн ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн байна, Оюунчимэг гишүүн ирсэн байна, Сарангэрэл гишүүн ирсэн байна, Чинбүрэн гишүүн ирсэн байна, Чинзориг сайд ирсэн байна, Идэрбат нарын гишүүд Байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна аа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн байгаа. 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Түүний дараа Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

Бэлтгэх ажлын хэсгийг байгуулна. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдоос 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх хэсгийг хийнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна. Энэ хуулийн төслийг өргөн барилцахад Нийгмийн бодлогын байнгын хорооноос Салдангийн Одонтуяа гишүүн байгаа, Бейсен гишүүн байгаа, Балжиннямын Баярсайхан нарын 14 гишүүн хамт өргөн барьсан байгаа юм.

Нямаагийн Энхболд даргыг танилцуулгаа хийхийг урьж байна. Нямаагийн Энхболд гишүүн бас Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа учраас жоохон хоцорч байна.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.

Ажлын хэсэг байгуулах тухай.
Гишүүд ээ.

Нямаагийн Энхболд дарга орж
ирж байна уу?

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь
хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын
байнгын хорооноос тогтоох нь:

09.40 цаг

Хууль санаачлагчийн илтгэлийг
Улсын Их Хурлын гишүүн Төрийн
байгуулалтын байнгын хорооны дарга
Нямаагийн Энхболд танилцуулна.

1. Монгол Улсын Засгийн газраас
2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр
Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм,
эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг
Байнгын хороо болон чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах,
санал, дүгнэлтийн төсөл боловсруулах
үүрэг бүхий ажлын хэсгийг дараах
бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Н.Энхболд: Байнгын хорооны
дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн ахлагч П.Анужин,
Улсын Их Хурлын гишүүн Нийгмийн
бодлогын байнгын хорооны дарга, ажлын
хэсгийн гишүүн Жаргалмаа, Улсын Их
Хурлын гишүүн Оюунчимэг, Улсын Их
Хурлын гишүүн Сарангэрэл, Улсын Их
Хурлын гишүүн Чинбүрэн.

Улсын Их Хурлын гишүүн Энхболд,
Адьяаа, Батжаргал, Бат-Эрдэнэ,
Баделхан, Баттөмөр, Бейсен, Дамдинням,
Учрал, Мөнхцэцэг, Цэрэнпунцаг,
Одонтуяа, Пүрэвдорж нарын гишүүдээс
Ахмад настны тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
санаачлан боловсруулж 2024 оны 05
сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн
мэдүүлсэн.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга
зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр
холбогдох байгууллагаас мэргэжлийн
хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг
ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Уг хуулийн төслийг санаачлан
боловсруулах хууль зүйн болон практик
шаардлагуудыг багцлаад танилцуулъя.

Нийгмийн бодлогын байнгын
хорооны дарга П.Анужин.

Том намын бүлгүүд, тухайлбал,
ахмад настан хагас цагаар гэртээ
зайнаас ажиллах уян хатан
зохицуулалтыг бий болгох мөн ахмад
настанд үзүүлэх урт хугацааны тусламж
үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог
бүрдүүлэх зорилтуудыг тусгасан байгаа.

Ажлын хэсэг байгуулах тийм санал
хураая.

Уг тогтоолын төслийг баталъя
гэсэн горимоор санал хураалт явуулъя.

2 дугаарт, 2017 онд шинэчлэн
найруулсан ахмад настны хуулийн
хэрэгжилт хангалтгүй. Үүн дотор
тухайлбал ахмад настанд зөвлөгөө өгөх
явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчлэх,
асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ
төрлийн үйлчилгээг бий болгож иргэн аж
ахуйн нэгж ТББ-аар гүйцэтгүүлэхээр
тусгасан ч санхүүжилт дутмаг,
хэрэгжилтийг нь хангах зохицуулалт сул
байгаагаас ахмад настанд дээрх
үйлчилгээнүүд хүрдэггүй, хэрэгжилт нь
хангалтгүй байгаа юм аа.

66.7 хувиар уг санал дэмжигдлээ.

Одоогоор байхгүй байгаа боловч
ажлын хэсэгт оролцох саналтай гишүүд
ажлын хэсэгт оролцох бол нээлттэй
байгаа.

3-т, хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь өсөж байна. Үүнтэй уялдаад насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээний болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг сайжруулах зайлиггүй шаардлага тулгараад байгаа.

Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр 2022 оны байдлаар нийт хүн амын 10.5 хувь буюу 10 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс нааш настан байгаа бол 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс настай байх ийм магадлал байгааг тооцоолж гаргасан байгаа юм.

4 дүгээрт, сүүлийн жилүүдэд хүчирхийлэл тэр дотроо гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын асуудал хурцаар тавигдаж байгаа. Ахмад настны эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байна гэсэн тоо байдаг. Янз бүрийн хэлбэрээр 2020-2022 оны байдлаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан ахмад настны эсрэг үйл үйлдэгдэж байгаа хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл тухайлбал эдийн засгийн хүчирхийлэл 36 хувийг эзэлж байна гэсэн ийм судалгаа гарсан.

Эдгээр байдлыг харгалзаж үзээд ахмад настны цогц урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх, санхүүжилтийг нь тодорхой болгох, ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох боломж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэх, ахмад настны хүчирхийллээс хамгаалах, өртсөн тохиолдолд буруутай этгээдэд үзүүлэх Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн шийтгэлийг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж энэ хуулийн төслийг санаачлан Их Хурлаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна аа.

Энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулаад

Ахмад настны нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах зэрэг 10 гаруй хуулийн төслийг боловсруулсан.

Энэ төслүүдэд дараах багц асуудлуудыг тусгасан байгаа. Энэ дээр 1 дүгээрт ахмад настанд үзүүлэх ахмад настны цогц үйлчилгээ, тэдэнд үзүүлэх цогц тусламж үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээнүүд, асрамжийн үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ, ахмад настанд үзүүлэх цогц тусламж үйлчилгээний мэргэжлийн удирдлага зэрэг нэр томъёонуудыг шинээр тодорхойлсон.

Ахмад настны цогц үнэлгээ, цогц тусламж үйлчилгээний заавар, үйлчилгээний үнэ тариф, үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон ахмад настны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтарч батлах, санхүүжилтийг нь тус тусын үйлчилгээтэй холбогдох зардлыг ЭМД-ын сан, нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс болон ахмад настны оролцоотойгоор санхүүжүүлэхээр тусгасан байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төв ажиллуулж байгаа бол тухайн барилга байгууламжийн барилга, хөдлөх хөрөнгийн ус, дулаан, цахилгаан зэрэг ашиглалтын мөн засварын зардлыг орон нутгийн төсвөөс хэсэгчлэн болон бүрэн хариуцан санхүүжүүлэхээр тусгаж байна.

4. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлиггүй шаардлагатай ахмад настанд жилд нэг удаа түши худалдан авах орон сууцын хөлс төлөхөд дэмжлэг үзүүлэх, протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 5 жилд нэг удаа үзүүлж байгааг 3 жил болгох. Ахмад настан зөвхөн рашаантай цөөн хэдэн

сувилалд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр сувилуулж байгааг магадлан итгэмжлэгдсэн сувиллууд болгон нэмэгдүүлэх зэргээр тэдэнд нэн тэргүүний хэрэгцээ саналд нь үндэслэсэн үйлчилгээг үзүүлэхээр тусгаад байна.

5.Ахмад настны асрамжийн үйлчилгээний нэр төрлийг нарийвчлан зааж тэдгээр үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан төлбөртэй, бага төлбөртэй, төлбөргүй зэрэг олон хэлбэрээр үзүүлэхээр мөн түүний санхүүжилт үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын талаар, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний ачааллыг үнэлж дэмжих, үнэлээд дэмжлэг үзүүлж байх талаар асуудлуудыг тусгасан.

Ахмад настны эсрэг эдийн засгийн хүчирхийллийн талаар нэмж холбогдох хуулиудад хариуцлагын заалтуудыг тодорхой тусгасан. Түрүүн би танилцуулсан. Жишээ нь, ахмад настны эсрэг үзүүлж байгаа тэдний эсрэг гарч байгаа хүчирхийллийн нэлээд хэсгийг нь эдийн засгийн хүчирхийлэл 36 хувь бараг 40 хувь нь эзэлж байгаа гэдгийг бас бид нар цаашидаа анхаарахгүй бол болохгүй ийм хэмжээнд хүрсэн байна гэж үзсэн.

Ахмад настны орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилгоор тэднийг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэхийг дэмжих эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой хэрэгжихүйц, хэрэгжих боломжтой гэсэн заалтуудыг тусгаж Монголын ахмадын байгууллагын статус чиг үүрэг, санхүүжилтийн талаар бас зарим заалтуудыг оруулсан байгаа.

Энэ хуулийг боловсруулахдаа бид нар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж

ирсэн хуулийн байгууллага Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбоо, ахмадад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, мөн ахмадуудынх нь өөрсдийн оролцоотойгоор олон удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж саналуудыг нь авч тусгасан байгаа. Засгийн газраас саналыг нь авсан. Засгийн газрын санал дотор бол бас хэлэлцүүлгийн явцад хэрэв хэлэлцэх эсэхийг нь дэмжвэл хэлэлцүүлгийн явцад авч болохоор тэрний дагуу залруулж болохоор ийм заалтууд байгаа гэж хууль санаачлагч нар үзэж байгаа юм аа.

Тийм учраас эрхэм гишүүд та бүхнийг энэ Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг нь дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Энэ хуулийг боловсруулахад оруулсан яамны бусад бидэнтэй хамтарч ажилласан ажлын хэсгийн гишүүд бас байгаа. Баярлалаа.

П.Анужин: Нямаагийн Энхболд даргад баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Юрагийн Отгонбилэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Нэргүйн Энхбат Юзисан Партнерс гэж хуулийн фирмийн зөвлөх хуульч. Эдгээр бүрэлдэхүүн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу?

Жигжидсүрэнгийн Чинбүрэн
Гишүүн. Цагаанхүүгийн Идэрбат
Гишүүнээр нэрсийг тасалъя.

Содномын Чинзориг сайд үг хэлье. Үг асуулт хамт явна. Үг хэлж, асуулт асууя. Үг, асуулт хамт шүү.

С.Чинзориг: Би зүгээр үг хэлчихье ээ. Яах вэ энэ гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг дэмжиж байна. Ахмадуудад тулгамдаж байгаа бас олон асуудлууд байдаг. Энэ бүгдийг бол нэлээн тодорхой болгож оруулах болов уу гэж бодож байна. Ер нь бол ахмадууддаа төр бас энэ халамж ивээлээ бас хүртээж одоо байх ёстой нийгмийн бүлэг гарцаагүй мөн. Гэхдээ ахмадуудын өмнө тулгамдаж байгаа олон асуудлууд бий.

Тухайлбал одоо энэ ахмад болсноос нь дараа тусламж үзүүлэхээс гадна энэ ахмад настанд бас бэлддэг сэтгэл зүйн бэлтгэл бас хангадаг, хангуулдаг эд нар гээд ийм бас нэг үйлчилгээнүүд шинээр бий болох юмнууд байгаа юм. Энэ бас нэлээн орж байгаа болов уу гэж бодож байна.

2 дахь асуудлууд нь ахмад настнуудад бид нар хэд хэдэн юман дээр л анхаармаар л байгаа юм даа. Бусад орнуудын туршлагыг ч гэсэн үзэхлээр ахмад настнууд боловсролоор тэгээд хүн чинь нөгөө олонтойгоо ажил хийж явахад хүн олонтой байдаг. Сэтгэл санаа их өндөр байдаг. Тэтгэвэрт гарахлаараа тэгээд л нэг яг гэрийн мухарт суучихдаг. Асар их их ганцаарддаг. Асар их сэтгэл санааны бас хямралд ордог, тийм асуудлууд байдаг юм шиг байгаа юм.

Тийм учраас бол энэ ахмадууд аль болохоор тэр хоорондоо бас уулздаг байх, санал бодлоо солилцдог байх, хууч хөөрдөг байх, ганцаардалд орохгүй байх, сэтгэл санаагаар өөдрөг байх энэ тэр гээд ийм

чиглэлийн үйл ажиллагаануудыг ялангуяа энэ хороо, сум, баг болгон дээр л одоо бий болгомоор л байгаа юм. Ийм чиглэлийн арга хэмжээг нэлээн бас өргөжүүлж өгөх хэрэгтэй.

2 дахь асуудал нь нэг амь орохгүй нэг хуулийн заалт яваад л байдаг юм даа. Одоо энэ яаж байгаа юм анхаарч байгаа болов уу? Ахмадын сан гээд нэг хуультай. Аж ахуйн нэгж, байгууллагууд нөгөө цалингийн сангийнхаа тодорхой хувь хэмжээгээр бас энэ ахмадын сандаа хөрөнгө төвлөрүүлж бүрдүүлэх ёстой ерөөсөө хэрэгждэггүй. Хэрэгжүүлбэ гэж шахалт шаардлага тавьдаг тавьж байгаа хүн байдаггүй, үр дүн байдаггүй. Амь ордоггүй ийм нэг сан байдаг байгаа.

Тэгээд энэ санг цаашидаа бид яаж бас өргөжүүлэх юм? Аж ахуйн нэгж байгууллагууд энэ хуулиар хүлээсэн үүргээ яаж одоо хэрэгжүүлэх юм? Энэ санг нь ахмадуудад өөрт нь юунд нь зарцуулж байх вэ эд нар гээд бас нэлээн анхаарах юмнууд байгаа юм.

Төгсгөлд нь зүгээр ер нь бол ахмадууд бас төрөөсөө дандаа ингээд хайр, халамж, ивээл нэхээд байдаггүй. Ахмад хүнд өөрт нь байгаа асар их одоо энэ капитал байна. Ажил амьдралын мэргэжлийн туршлага байна. Энэ туршлагыг нь бид нар бас аж төр бас ашигладаг байх. Ахмадын зөвлөх үйлчилгээг нэлээн өргөжүүлж өгнө гээд бид нар яг өмнө нь яриад л хуульд оруулж байсан. Гэхдээ энэ бас нэг их тэгж газар аваад нэг их өргөн сайхан болчихгүй байх.

Ялангуяа бид нар энэ залуучуудыг чинь энэ хүүхдийн хүмүүжил төлөвшилтэй холбоотой Монгол хүн болгож хүмүүжүүлж, Монгол ахуйтай, Монгол ухаантай ийм иргэн болгож төлөвшүүлнэ гээд байдаг. Энэ ажилд энэ ахмадуудыг төрдөө зүтгэж ирсэн энэ асар их энэ туршлага, мэдлэг боловсролыг л бид ашиглах ёстой л байгаа юм даа. Үүнийг нэлээн бас өргөжүүлж өгч нэлээд тийм амьд ажил болгох асуудлууд байна.

Ядаж л энэ залуу малчид манай ахмадууд ч байгалийнхаа шинж байдлаар л байгаль цага агаараа шинжсдэг асар их Монгол ухаан байна шүү дээ. Үүнийг л гэхэд л залуу малчдад сургаж баймаар байх юм.

Төгсгөлд нь энэ манай яаман дээр яриад бас нэлээн дэмжиж болохооргүй асуудлууд байна гэж яриад байсан юм. Тэгэхээр үүнийг дэд ажлын хэсэг байгуулахдаа Байнгын хорооны дээр анхаарна биз. Манай яамнаас зайлиггүй төлөөллүүдийг нь оруулаарай. Тэгээд тэр ажлын дэд хэсэг дээрээ ажлын хэсэг дээр яриад манай яамны тэр саналуудыг бас авах боломжтойг нь авах боломжгүйг нь тэгээд бас ойлголтоо нэгтгээд цаашаа явах талаар.

П.Анужин: Чинзориг сайд санал хэллээ. Хэлсэн саналуудыг ажлын хэсэг байгуулах явцад тусгаад ажиллана. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлье.

Үг хэлж, асуулт асууна. Хамт явж байгаа.

Ж.Чинбүрэн: Би бас дэмжиж, санал хэлье ээ. Бас энэ чухал хууль орж ирж байна. Ер нь бас Чинзориг сайд бас зөв хэлж байна. Ер нь бол нэг ажил хөдөлмөр эрхэлж байгаад нэг тийм амьдралын мөчлөгөөс нөгөө мөчлөг рүү шилждэг. Сэтгэл зүйн болон амьдралын хэв маягийн энэ том өөрчлөлтөд манай ахмадууд бэлэн байж чаддаг уу гэдэг асуултад бид бас статистикийн зарим тоо баримтууд байдаг аа.

Тухайлах юм бол бид энд бол ерөөсөө энэ сэтгэл санааны сэтгэл зүйн их тийм дарамтыг даван туулах. Түүнд дасан зохицох энэ үйл ажиллагааг дэмжиж өгөх асуудал өөрөө их чухал байдаг.

Тэгэхээр бол энэ хуульд ахмадын асуудлыг хуульд оруулахдаа цогц асуудлаар нь оруулж эрүүл мэнд гэдэг нь зөвхөн бие бялдрын эрүүл мэндийн асуудал

биш. Энэ бол сэтгэл зүйн эрүүл мэнд гэдгийг бас оруулж өгсөн бол их сайшаалтай санагдаж байна. Тэгээд бид бас энэ ахмадууддаа дэмжих асуудлуудыг илүү түлхүү энэ хуульд оржээ. Сая бид 2023 онд бас баталсан том чухал хууль бол Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль байгаа.

Энэ хуульд бол бас энэ ахмадын Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ асуудлууд хүртэл бас холбоотой хамрагдах ёстой.

Дээрээс нь эрүүл мэндтэй холбоотой олон асуудлууд байна. Бид ахмадуудыгаа нэг хэдэн рашаан сувиллаар л нэг аргалчхаад байдаг.

Тэгээд өөр нэг их олигтой тийм дэмжлэг үзүүлдэг төвүүд байхгүй тэр нь санхүүгийн эх үүсвэр байхгүй байгаа байдлыг энэ хуулиар шийдэх гэж байгаа нь өөрөө их нэлээн тийм онцлох сайн нэмэлт, өөрчлөлтөө гэж харж байгаа юм.

Тийм учраас бид насаараа хөдөлмөрлөж энэ улс эх орны хөгжилд амьдралаа зориулсан хувь нэмрийг нь үнэлж ахмад настай болоход нь дэмжлэг үзүүлдэг байх бодлого энэ хуулиар харагдаж байна гэж бодож байгаа.

Нөгөө талаасаа бас ер нь дэлхий даяараа насжилт нэмэгдэж байна.

Монгол Улс ч гэсэн дундаж нас хэд дахин нэмэгдсэн байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор өндөр настны өвчлөл гэдэг бүүр тусгай тийм сэдэв байдаг. Энэ бүүр шинжлэх ухаанаар герентология гэдэг бүр том шинжлэх ухаан. Тэгэхэд бид үүнтэй бас уяж холбож герентологийн Үндэсний төв гэж Монгол Улсад байгаа. Эдгээрийн манлайллыг бас бий болгоход бас энэ хууль бас өөрөө хувь нэмрээ оруулж, тэдгээрийг татан оролцуулах манлайллын гаргахад бас дэмжлэг үзүүлж байх ёстой юм.

Тэгээд бид яах вэ, энэ мэдээж хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явсны дараа ажлын хэсэг байгуулагдах байх. Тэгэхээр ажлын хэсэг дээрээ бас энэ зарим нэг зүйлийг нэмээд, сайжруулаад, тэгээд их тийм тэтгэврээрээ асрамжийн газар хүртэл байх энэ боломжийг бүрдүүлнэ гэдэг өөрөө бас их том чухал шийдвэр шүү.

Тийм учраас бүх талаар дэмжинэ ээ. Энэ хуулийн төслийг дэмжиж байна.

П.Анужин: Чинбүрэн гишүүн дэмжиж үг хэллээ.

Асуулт асууж, үг хэлэх гишүүдийн тоонд Бадарчийн Жаргалмаа гишүүний нэрийг нэмж өгөхийг ажлын хэсгээс хүсэж байна.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн үг хэлж асуулт асууна.

Ц.Идэрбат: Энэ Ахмад настны тухай хууль бас их чухал хууль аа. Энэ Байнгын хорооноос 2022 онд Ахмад настны хуулийн хэрэгжилтийг бас танилцах ажлын хэсэг гарч Жаргалмаа гишүүн бид бас ажиллаж байсан. Эндээс бас нэлээдгүй олон саналуудыг энэ ахмадуудтай уулзах мөн ахмадын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа янз янзын байгууллагуудаар очиж уулзах гээд бас нэлээн бас чамбай ажиллахыг хичээсэн. Түүнийхээ талаар бас нэлээн одоо Нийгмийн бодлогын байнгын хороонд бас танилцуулж байсан.

Нэгдүгээрт бид энэ тухайн үед яригдаж байсан энэ ахмад настны тэр Үндэсний Герентологийн үндэсний төв. Тэр одоо ер нь юу болж байгаа вэ? Би тэр хаана байдгийг нь ч мэдэхгүй. Яг үнэнийг хэлэхэд. Үндэсний төв гэхээр л энэ Хавдар судлал шиг, Халдвар ч шиг эсвэл одоо 1, 2, 3 дугаар эмнэлэг шиг тийм том юм руу очих юм болов уу гэж бодоод очсон. 100 айлд нэг байрны нэг жоохон талбайд тийм өрхийн эмнэлэг ч байхгүй шүү дээ.

Тэгээд ахмадад зориулсан Үндэсний төв гээд нэр нь томдчихсон. Дотроо тэр чинь хүн үзэх нь битгий хэл эмч нь суух өрөөгүй тийм юм хийчхээд энэ асуудлаа хурдан шийдмээр байгаа юм. Тэр хууль хяналтын байгууллага байдаг бол хурдан тэгээд хууль хяналтын байгууллагад дөхчихсөн гээд ингээд суугаад байна. Энэ ахмадууд чинь өдрөөс өдөрт л цөөрөөд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр энэ яам нэлээн анхаарч ажилламаар байна гэж би хэлэх гэж байгаа юм.

2 дугаарт, энэ хууль дээр бас нэлээн юмнуудыг нээж өгч байна. Сая Чинзориг сайдын ярьж байгаа тэр ахмадын сан байгуулна гээд ингээд хууль дээрээ тусгачхаад тэгээд их ойлгомжгүй, ойлгомжгүй юм орон нутагт ажиллаж байхад байдаг юм шүү дээ.

Ахмадын сангийн хууль дээрээ ахмадын сантай бай гээд хэлчихнэ. Тэгээд санг нь байгуулчихаар аудит нь түүн дээр зөрчил тавиад, акт тавиад. Тэгээд нөгөө нэг хуулийг нь хэрэгжүүлэх ч хэцүү, байх ч хэцүү.

Тэгээд ялангуяа орон нутагт одоо орон нутгийн төсөвт байгууллагууд өөрсдөө тавьчихдаг юм шүү дээ. Энэ босоо удирдлагатай энэ байгууллагууд чинь төсөв дээрээ тавьж өгдөггүй юм. Тэгсэн хэрнээ бид нар өнөөдөр энэ хууль дээр ахмадын сан байгуулж байгаа л гээд яриад байгаа.

Тэгэхээр энэ хуулийнхаа хэрэгжилтийг бас хоёргүй хоёрдмол утгагүй хэрэгжүүлэх тал дээр анхаармаар байгаа юмгээж би хэлэх гээд байна.

Дараагийнх нь орон нутагт ингээд ажиллаж байхад энэ ахмадууд чинь зайлуул, нэг нь харьяалалтай, нэг нь ажиллаж байсан байгууллагууд нь татан буугдчихсан ийм ахмадууд байгаад байдаг. Ахмадын баяраар бол нөгөө

байгууллагынхаа ахмадуудыг байгууллага нь хүлээж аваад байдаг. Тэгээд хэн нэгэн урьдаггүй, тийм байгууллага нь байхгүй болчихсон ахмадууд бол бас сэтгэл зүйн хувьд их хүнд байдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр ахмадуудад нэг жилдээ 20 мянган төгрөг цагаан сар, наадмаар нэг 10, 10 мянган төгрөг өгдөг. Тэгээд энэ Засгийн газрын журмаар явдаг юм байна лээ. Тэгээд цагаан сарын үеэр ч яах вэ нэг еэвэн авч өгөөд л зайлуул тэгдэг байсан. Одоо тал еэвэн ч хүрэхээ байсан тэр мөнгө нь. Тэгэхээр ер нь бол энэ үнэхээр л ахмадууддаа бас нэг баярлуулъя энэ гар дээр нь юм тавья гэж бодож байгаа бол үүнийгээ ч гэсэн нэг хармаар санагдаад байгаа юм.

Дараагийн нэг юм нь энэ яг хууль дээрээ ер нь ахмадууд сэтгэл зүйн маш их тайтгарал авдаг баяр хөөртэй байдаг юм ахмадууд цуглах тэр газар байдаг. Тэнд тоглоом, наадам бүжиг болж байхад ахмадууд маш их эрч хүч авч байдаг шүү дээ.

Тэгэхээр орон нутгуудад энэ ахмадын байрны асуудал одоо хууль дээр зөвхөн үйл ажиллагааны зардал гэж нэг үг байгаад байгаа. Тэгэхээр тэр ахмадуудыг манлайлаад зохион байгуулж байгаа хүмүүстээ нэг орон нутгаас нь тэр урамшууллынх нь асуудлыг шийдэх юмыг нээгээд тавиад өгчихвөл энэ үйл ажиллагаа тогтмолжоод энэ ахмадууд бол бас тэр ахмадын байран дээрээ ирээд бас хөгжсөөд байх ийм л бололцоо байдаг.

Дараагийн нэг юм нь миний Баялгийн сангийн хуулиар тэр хуримтлалын сан дээр эрүүл мэнд, боловсрол, орон байр гэж байгаа. Тэгэхээр энэ эрүүл мэнд гэдэг дээр ахмадууд маань одоо энэ.

П.Анужин: Түрүүн нэг бодит байдлын талаар асуулт асуусан учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулах нь зүйтэй.

Ундрал дарга хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Ахмадын асрамж, халамжийн өнөөгийн байдал тэр асрамжийн ахмадын газрын талаар тодорхой асуултад хариулъя.

Ахмадын сангийн талаар асуусан тийм үү? Ахмадын сангийн талаар хариулт өгчихье.

Ундрал дарга.

Б.Ундрал: Идэрбат гишүүнтэй санал нэг байгаа. Бид нар энэ хуулийнхаа зохицуулалт дээр бол ахмадын сангийн зохицуулалтыг тодорхой тусгасан байгаа.

Дээрээс нь Компанийн тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулж байна. Ахмадын сан бол өөрөө 3 хувь хүртэлх, тухайн төсвийнхөө 3 хүртэлх хувийг бүрдүүлж ахмадууддаа зориулах тогтолцоог бид нар Компанийн тухай хууль дээр, мөн дотоод журам, байгууллагын дотоод журам дээр заавал тусгаж тусгайлан журмаар хэрэгжүүлэх хэрэгжилтийнх нь шатуудыг нь нэлээдгүй дэлгэрэнгүй оруулаад явж байгаа. Одоогийн байдлаар улсын хэмжээнд Ахмадын сан ажиллуулж байгаа 6 мянга гаруй байгууллага ажиллаж байна.

Цаашидаа яг энэ хуулийн шинэчлэлээр бид бид нар бас хэрэгжилтийг нь аягүй сайн хангуулахаар зохицуулалт хийсэн байгаа. Асрамжийн газрын улсын хэмжээнд 400 гаруй ахмадууд одоо хамрагдаад үйлчилгээгээ аваад явж байна. үүний дотор бол сая бид нар сайдын тушаалаар норм нормативын зардлыг нь бол 2 дахин нэмэгдүүлж өгсөн байгаа.

Ингэснээрээ мах болон түүхий эдүүд нь сайжирч тендерийнх нь асуудлууд жигдрээд явж байна гэж харж байгаа. Сая 2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжээд явж байгаа.

П.Анужин: Герентологийн асуудлыг эрүүл мэндийн сайд Чинзориг хариулаад, дараа нь Идэрбат гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Идэрбат гишүүний асуултад хариулахад энэ Геронтологийн төвийн барилгатай болно гээд олон жил болж байгаа юм байна лээ. 2011 онд Герентологийн төвийн барилга барина гээд ингээд мөнгө нь тусгаад явсан. Одоо ингээд бараг л 13 жил ч одоо болж байна. Манай Жаргалмаа гишүүн бол маш сайн ойлголттой олон жил яриад байгаа юм.

Тэгээд ингээд 2011 оноос эхэлсэн барилга одоогоор дуусаагүй. Нийтдээ 6 тэрбум төгрөгийн зарцуулалт гарчихсан гүйцэтгэл гарчихсан байдаг. Тэгээд энэ барилга нь цаашид ашиглах боломжгүй гээд ингээд бас дүгнэлт гарчихсан. Тэгээд үүнийг нь бид нар хууль хяналтын байгууллагад өгөөд явж байгаа шүү. Одоо шүүх цагдаагаар явж байгаа. Одоо тэр барилгыг нь ашиглах боломжгүй гэсэн учраас ядаж тэр гүйцэтгэгч компаниас нь тэр зарцуулчихсан байгаа 6 тэрбум төгрөгөө нэхэж олгох улсыг хохиролгүй болгох гээд ингээд хууль хяналтын байгууллагад өгөөд ажиллаж байна.

Харин Герентологийн барилгыг бид нар нэг өөр сувиллын чиглэлээр баригдсан нэг барилгад шилжүүлж байгаа. Үндсэндээ бол герентологийн төв бол тийшээ нүүж ороод үйл ажиллагаа явуулахад бэлэн болж байна. Гэхдээ тэр нь бас яг нөгөө зориулалтын барилга биш учраас бол бас тийм нэг багтаамж сайтай биш гэж өөрсдөө яриад байгаа юм. Гэхдээ одоогийн байгаа энэ нөгөө жижгийгээ бодвол бас шинэ барилга маань арай дээр болох байх гэсэн ийм л ийм нэг рамтай л тэгээд хоцорчхож байгаа юм байна лээ.

П.Анужин: Идэрбат гишүүн тодруулж асууя.

Үг хэлж, асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалаар.

Ц.Идэрбат: Герентологийн байшин дээр одоо тэгээд Оюунчимэг гишүүнийг тэр хувийн хэвилийн юм уу, төрийн буруу юм уу, хэнийх нь буруу юм тэр хууль хяналтын байгууллага шийдэх байлгүй. Тэгээд түүний бурууг ахмадууд үүрээд герентологийн төвгүй байгаад байна гэж бас боломгүй л санагдаад байгаа шүү дээ. Тэгээд хэзээ тэр нь шийдэгдэх юм. Зөндөө зовлон байгаа.

Тэгэхээр энэ дээр бас нэг жоохон арай өөр өнцгөөс одоо хармаар юм уу гэж би нэгдүгээрт хэлмээр байна.

2 дугаарт, тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан миний асуултыг сайн ойлгоогүй юм шиг байна. Тэр хууль дээр ямар дүрэм журам байгааг чинь би мэдэж байгаа. Наадах чинь орон нутагт хэрэгждэггүйг би яриад байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ засах юм уу, засахгүй юм уу? Наадах чинь та бол компанийн дотоод үйл ажиллагаа, тэр дүрэм журам яриад байна. Төрийн байгууллагууд төрийн байгууллагынхаа юмыг үгүйсгээд байгаа. Хууль дээр ийм хоёрдмол утгатай. Одоо жишээ нь Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар цалингийн сангийнхаа 3 хувиар ахмадын сан байгуулсан уу? Яг үүнээс эхэлмээр байгаа байхгүй юу.

Тэгэхээр 2017 оны хууль дээр байгаа 7 жилийн дараа хэрэгжихгүй байна гэдгийг яриад байхад та 2017 оны хуулийн өгүүлбэр.

П.Анужин: 2 номерын микрофон өгье. Отгонбилэг дарга хариулт өгье.

Ю.Отгонбилэг: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Энэ өргөн барьсан хуулийн төслийн энэ 14 дүгээр зүйл дээр мөрдөж байгаа хууль дээр бол юу байгаа юм. Одоо төсөвт байгууллага үйл ажиллагааны орлого үлдэгдэл ашгаасаа гэхихсэн.

Тэгэхээр аудитын хэлж байгаа дүгнэлт нь болохоор одоо яг ингээд төсөвтөө та нар суулгаагүй үүнийг ашигласан байна гэсэн асуудал 50-аад байгаа.

Ийм учраас энэ хуулийн төсөл дээр төсөвт байгууллага нөгөө нэг тухайн жилийнхээ төсөвтөө тусгана гэсэн заалтыг нь оруулаад өгчихсөн.

Тэгэхээр Сангийн яам ч гэсэн үүнийг дэмжсэн. Яг нөгөө төсвийнхөө зүйл ангид тусгайлан оруулж өгөөд төсөвт байгууллага блд хэрэгжүүлчих юм. Хувийн байгууллагын хувьд болохоор энэ хуулийг дагасан хуулийн төсөл дээр Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай гээд хуулийн төсөл оруулчихсан байгаа. Энэ хууль дээр болохоор компани дүрэмдээ Ахмадын сан байгуулах гэсэн үйл ажиллагааг дүрэмдээ тусгасан байх ёстой.

Тэгээд энэнийхээ дагуу Удирдах зөвлөл нь журмаа батална гэсэн заалтуудыг тодорхой заагаад.

П.Анужин: Баярлалаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Энэ хууль орж ирж байгаад бас баяртай байна. Уг нь амжаад бас чуулганыхаа бүрэн эрхийн хугацаанд энэ хуулиа уг нь баталчихдаг бол тун таатай яа. Үнэхээр 2022 онд Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос үүрэг өгсний дагуу Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгээ байгуулж, хөдөө орон нутгаар ажиллаж яг саяын Идэрбат гишүүний хэлээд байгаачлан орон нутаг ахмад настан руу чиглэсэн үйл ажиллагаа болон сангийн үйл ажиллагаа хэрхэн ямар зохион байгуулалттай байгаа юм. Өнөөдөр төрөөс үзүүлж байгаа халамж асрамжийн үйл ажиллагаа болоод хуулийн хэрэгжилт ямар байгааг бас бид нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхантай явж танилцсан байгаа.

Үнэхээр хуулийн хэрэгжилт бас хангалттай бус, ахмадууд маань төрөөсөө нөгөө л харсан горьдсон үйлчилгээтэй хэвээрээ байсан.

Тэгэхээр энэ бүхэн дээр бас тодорхой хэмжээний үүрэг чиглэлийг Засгийн газарт өгөх Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүргийг бас Улсын Их Хуралд Засгийн газарт чиглэл болгох ийм тогтоолын төслийг Байнгын хорооноос баталсан.

Тэгээд яг энэ хууль орж ирж байгаатай холбогдуулан мэдээж ажлынхаа үр дүнг харахын тулд тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих одоо тийм боломж байдаг.

Анужин дарга бас бидэнд энэ боломжийг нээж өгөөч ээ. Явсан газар нутагтаа бидний хэрэгжүүлсэн гэдэг юм уу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас амалсан энэ ажил ер нь хэрхэн ямар биелэлттэй байгаа юм бэ гэдгийг шалгах тэр боломж байгаа болов уу гэдэг дээр бас санал тавиад албан ёсоор танд санал хүргүүлье.

Үнэхээр одоо энэ хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллаж байх үед ахмадууд маань төрөөс чанартай насжилтыг шаардсан. Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх тэр боломжийг шаардсан. Үр хүүхдүүдийн хүчирхийлэл дунд гэдэг юм уу? Тэтгэврээ буухаар тэдэндээ өгчихдөг бус өөрсдөдөө зарцуулах сайн дурын даатгал байдаг бол бид нар даатгуулах байсан юм. Өөрөө өөрсдөө зарцуулах мөнгөтэй болох байсан юм гэдэг зүйлийг ярьж байсан. Энэ ажлын хүрээнд Нийгмийн бодлогын байнгын хороо ч гэсэн Японы сайн туршлага судлах нэг хэлэлцүүлэг хийж байсан. Тэнд асрамжийн даатгал гэдэг зүйл байсан. Яг энэ хууль дээр ахмадын хууль дээрээ бас уг нь энэ даатгалын асуудлыг бид нар бас тодорхой хэмжээнд санал болгох юм уу, орлуулах үйлчилгээ ямар боломж байгаа юм бэ гэдгийг бас

харах зайлиггүй шаардлага байгаа байх гэж би бодож байна.

Энхболд дарга Улсын Их Хурал дээр бас ахмад настны тухай ахмадын хууль, эрх зүйг сайжруулах Лобби бүлэг байгуулахад нэн түрүүнд гараа өргөөд уг нь орсон байгаа. Тэгээд энэ ажилдаа бас тийм ээ тодорхой хэмжээний саналуудаа өгөөд хуулийн ажлын хэсэгт ороод ажиллая гэдэг саналаа бас тавья гэж бодож байна.

Ер чанартай насжилт гэдэг дээр бид маш сайн харах ёстой. Сая Геронтологийн төвийн асуудлыг нэгэнт ярьчихсан болохоос би дахиж яриад яах вэ. Гэхдээ үнэхээр 2023 оны 11 сард 46 ортой эмнэлгийн үйл ажиллагаа явуулах тэр барилгыг хүлээлгэн өгнө гэж байсан боловчиг өнөөдрийг хүртэл Геронтологийн үндэсний төв маань шинэ байр руу нүүж очоогүй.

Хишигжаргал захирал маань байнгын холбоостой л байгаад байгаа.

Тэгэхээр төрөөс ахмад настанд үзүүлэх асрамжийн үйл ажиллагаагаа бид нар яг яаж явуулах юм. Гэрээр үйлчилгээ авах тэр боломжийг нь яаж өгөх юм. Магадгүй түрүүний Чинбүрэн гишүүний хэлсэнчлэн бид бүгдээрээ одоо ахмадууд болох энэ цаг мөчид тэр шилжилтийн үеийн сэтгэл зүйг бэлтгэх, тэр боловсролыг олгох, тэр геронтологийн ахмад настны шинжлэх ухааныг судлах тэр судалгааны байгууллагыг нь бий болгох тэр боломжоо бид нар бас ахмад настны тухай хуульд бас оруулж өгөх нь зөв болов уу гэж бодож байна.

Тэгэхээр ахмадуудынхаа тэр хүслийг гүйцээсэн зөвхөн нэг асрамжийн газраар үйл ажиллагаа явуулах бус өдөр өнжүүлэх хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, гэрийн асаргааг одоо нэмэгдүүлэх сайн дурын асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаа хэрхэн яаж дэмжих юм?

Улсын хэмжээнд байдаг асрамжийг магадлан итгэмжлэгдсэн хэдхэн байгууллагадаа нөгөө л хороо хэсгээрээ явдаг нэг хэдэн ахмадуудаа хамруулчихдаг тэгш хүртээмжтэй байх тийм ээ. Гэртээ байгаа тэр ахмадуудад хүргэх, ахмадаа асрахгүй байгаа тэр одоо гэр бүлд ч гэдэг юм уу тодорхой хэмжээний үүрэг хариуцлагыг нь хүлээлгэдэг байх тэр зарчмыг бас энэ хуульдаа өгөх зайлиггүй шаардлага байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Би Их Хурал дээр байнга хэлдэг. Төр байгаа энэ Арвис гэдэг компанитай хариуцлага тооцож 6.8 тэрбум төгрөгөө олж аваад газар аваад дахин барилгаа нэг эхлүүл.

П.Анужин: Бадарчийн Жаргалмаа гишүүн чухал саналууд хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн болж сонгогдсоноосоо хойш ахмадын ажлын хэсгийг санаачлан байгуулж энэ тал дээр маш идэвхтэй бодитой ажлууд хийсэн. Одоо ч бас энэ тал дээр дуу хоолойгоо өргөсөөр яваа. Тодорхой сэдвүүд дээр маш сайн ажиллаж байгаа. Ийм Байнгын хорооны гишүүн гэдгийг Байнгын хорооны хурал дээр бас онцлон хэлэхийг хүсэж байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

М.Оюунчимэг: Ахмадын тухай хуульд шинэчилсэн найруулгаар ингээд орж ирж байна. Хаврын чуулганаар орж ирээд батлагдаасай гэсэн хүлээлт ахмадуудад их байлаа. Сая бид нар Энхболд дарга бүх дүүргүүдэд очиж энэ ахмадуудын төлөөллүүдтэй нэг бүрчлэн уулзаж санал бодлыг нь сонссон. Үүний дараа би бас жишээ нь Чингэлтэй дүүргийнхээ бүх хороодын ахмадуудын санал бодлыг сонсож явлаа.

Сая СБД-ийн ахмадуудтай бас Цогтбаатар гишүүн бид нар бас уулзаад ингээд санал бодлыг нь сонссон. Тэгээд энэ

хууль дээр хамгийн их тэд нарын хүсээж хүлээж байгаа зүйл нь юу байна гэхээр энэ тэтгэврийг жишээлбэл нөгөө 20 жил хамт амьдарсан бол өвлөгддөг байна гэдгийг хүмүүс их шүүмжилж байна. Яагаад гэвэл 20 жил гэдэг бол бас нэлээд урт хугацаа хатуу байна аа. Энэ цаг хугацааг нь жоохон наашлаад 15, 10 гэж болдоггүй юм уу?

1 дүгээрт, энэ дээр бас анхаарч өгөөч.

2 дугаарт нь, ахмадууд маань өнөөдөр ач зээгээ хараад л гэртээ ихэнх нь тиймэрхүү байдалтай байгаа. Тэгээд нөгөө хороо дүүргүүдэд ахмадын байртай байнагээд. Хэдийгээр нөгөө өмнөх ахмадын хуульд заасан ч гэсэн тэр нь хэрэгждэггүй. Тэрийг хэрэгжүүлэх санхүүжилт нь хороо дүүрэгт байхгүй. Дүүрэг нь гаргая гэхээр үгүй ээ, одоо яг энэтэй холбоотой санхүүжилт уг нь байж байгаа ч гэсэн яг манай дээр тусгагдаагүй ч гэдэг юм уу хороо угаасаа ямар ч санхүү мөнгө байхгүй.

Тэгэхээр энэ одоо хүртэл хэрэгжихгүй байгаад байна л даа. Тэгээд ийм саналууд гарч байсан. Нөгөө Нийгмийн эрүүл мэндийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлж байгаа шүү дээ. Тийм ээ Чинзориг сайд аа. Энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль дээр заасанчлан нөгөө ахмадын өргөө гэдгийг эрүүл мэнд өвчлөхгүй байх, урт наслах энэ зүйлтэйгээ уяад ингээд хийчихвэл зүгээр юм биш үү. Ахмадын байр юм уу ахмадын хөгжил гэж байсантай энийг энэ нийгмийн эрүүл мэнд урьдчилан сэргийлэх одоо иог хийдэг юм уу нөгөө нэг янз бүрийн дасгал хөдөлгөөн энэ тэр хийдэг тийм зүйлтэйгээ уяад ингээд Ахмадын өргөө гэдгийг хийчихвэл нэг зүгээр байна гэсэн саналууд их гарч байсан. Тэгээд үүнийг хэр тусгаж өгч байна гээд.

3 дахь зүйл нь хөдөлмөрлөх боломжоор олгох. Хагас болон бүүр боломжтой бол нөгөө бүтэн гээд байгаа тийм ээ. Тэтгэврээ авдаг ч гэсэн, авдаг ч

гэсэн эрүүл мэндийн салбарт ясли, цэцэрлэг дээр гэдэг юм уу, маш олон боловсон хүчин дутагдалтай байхад жишээ нь нэлээд 55 юм уу, 60-тай маш мундаг эмч нар байж байна, багш нар байж байна. Энэ хүмүүсийг болж өгвөл бүтэн цагаар ажиллуулах үнэхээр тэр шаардлага хангасан нөхцөлд нь л заримыг нь хагас цагаар ажиллуулъя. Тэр нь хөдөлмөрийн хөлсний яг бодит үнэлэмжээр үнэлээд явчихдаг байх нь 1 дүгээрт их чухал байна гэсэн.

Тэгээд энэ зүйлүүдийг энэ дээр тусгаж оруулж өгсөн үү? Энэ саналуудыг бид нар бас өгсөн байгаа. Иргэдээс ийм санал гарч байна гээд.

4 дэх зүйл нь юу юм гэхээр өнөөдөр манай Батсүмбэрийн нөгөө ахмадын байр байгаа. Хоёрхон л газар байх бараг тийм ээ. тэрний нөхцөл байдал тэр яаж ахмадууд маань тэнд очоод олон дунд сэтгэл санаа тайван ийм байх, эсрэгээрээ бараг хүйтэн, бас хавчигдмал, хоол унд муутай, нэлээд их асуудалтай. Манай эмэгтэй гишүүд олон удаа Батсүмбэрийн тэр ахмадын газар очсон. Асрамжийн газар очиж байсан. Тэгээд бүгд асуудлаа ярьж байсан л даа. Наад зах нь хоол унднаас өгсүүлээд тэгээд санхүүгийн бололцоо муутай. Чөлөөтэй орж гарах гэхээр замаас өгсүүлээд ер нь үнэхээр хүндрэлтэй. Эрүүл мэндийн хувьд ч гэсэн гэж байгаа юм.

Тэгэхээр бид нар одоо энэ хуулийг хэрэгжүүлэхдээ Булгантуяа сайд л хариулах байх даа. Одоо яг Хот, тосгоны тухай хуульд шинэчилсэн найруулгаар орж ирээд энэ 2025 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ гэж байна. Хот дотор хот болоод 52 зөвлөл гээд эргээд энэ маань задрах гэж байна. Тэгэхээр энэтэй уяад энэ ахмадын хууль маань дахиад шинэчилсэн найруулгаар орж ирж байхад тэр хууль маань шинэчлэгдээд ороод ирэхэд энэ дээр дүүрэг болгон тийм юмтай байна энэ нь гээд бас зөрчил ч үгүй түүнтэй яаж уялдаж байна? Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтээ

уяад энэ дээр өөрчлөлтүүд их байгаа шүү дээ. Орох ёстой нөгөө хувийн тэтгэврийн тогтолцоо маань хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? Одоо ярьж байна шүү дээ, би ингээд л нийгмийн даатгалын шимтгэл, ЭМД-ын шимтгэл залуу наснаасаа төлөө л байсан, төлөө л байсан. Одоо би яг тэр хэмжээгээр авч чаддаггүй. Сая тодорхой хэмжээгээр тэтгэвэр нэмэгдсэн.

П.Анужин: Хууль санаачлагч Нямаагийн Энхболд дарга эхэлж хариулаад, Булгантуяа сайд, тэгээд Хишигбаяр дарга сүүлийн тэр нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хариульа.

Н.Энхболд: Энэ хууль маань нэлээн дэмжигдэж байгаа юм. Их Хурал дээр энэ яг ахмадын асуудлыг хамарсан эрх зүйн зохицуулалтуудыг хийх ийм лобби бүлэг гэж байгаа. Одоо 26, 27 гишүүнтэй. Тэд нарынхаа санал гомдлыг ч бас энд тодорхой тусгасан. Би үүнийг яагаад хэлж байна гэхээр тэгэхээр ийм олон гишүүн дэмжлэг байгаа учраас энэ чуулганаар бид нар энийг ямар нэгэн байдлаар сайн хэлэлцээд заавал гаргаж авах ёстой гэж ингэж үзэж байгаа. Лобби бүлгийн гишүүд маань зарим нь энэ хуулиа санаачилсан, зарим нь бид нар ажлын хэсэгтээ орж ажиллаад хуулиа гаргана шүү гэж ярьж байгаа.

Тэгэхээр Анужин дарга хоёулаа ярьж байгаад тэр хүмүүсээс ажлын хэсэг байгуулах миний бодлоор бүүр бараг Их Хурлын даргаар захирамж гаргуулж байгаад бүх Байнгын хороодоос орсон төлөөллөө хийгээд ажлын хэсэг байгуулчхаж болох байх гэж бодож байна. Ерөөсөө сая Оюунчимэг гишүүний ярьсан санаанууд бид нар яг л таны энэ яриад байгаа зүйлүүдэд л гол одоо өөрчлөлт гаргах гэж энэ зүйлүүдийг хийсэн. Ялангуяа энэ хөдөлмөр эрхлэх боломжийг нь шинээр нээж өгөх тухай асуудал байгаа юм. Тэтгэвэрт гарчихсан хойноо.

Тэгээд энэ бол зүгээр хүн хүсээд очихоор нь байгууллага үзэмжээрээ аваад ажилладаг биш. Энэ хуулиар бас байгууллагуудад ийм хүмүүсийг ажиллах боломжийг нь нээж өгөөд тэгээд дээр нь тэр байгууллагын хүлээх үүрэг хариуцлагуудыг нь нэлээн тодорхой болгоод өгчихсөн болохоор эндээс хэдийгээр тэтгэвэрт гарчихсан ч гэсэн оюун санаа бие хаа нь эрүүл байгаа ахмадууд хөдөлмөр эрхлэх боломж илүү их нээгдэнэ гэж ингэж найдаж байгаа.

Ингэснээр түрүүн бид нарын олон дахин яриад байгаа жишээ нь нэг мөчлөгөөс мөчлөгт шилжих хооронд хямралд ордог асуудал байна шүү дээ. Энэ тэр тодорхой хэмжээгээр энэнд нөлөөлөх ёстой. Нөгөө хамт олонтой байдаг асуудал нөгөө одоо би хэрэггүй болчихлоо гэж сэтгэл санаагаар унадаг гэх мэтчилэн байдлууд бүгдээрээ арилна гэж найдаж тэр заалтууд дээр нэлээн анхаарал тавьсан байж байгаа. Асрамжийн газар бас ялгаагүй. Үнэхээр би бол Батсүмбэрээс сонгогдсон гишүүн л дээ.

Тэр асрамжийн газрын байдлыг үнэхээр сайн мэднэ. Явал өөрчлөх вэ гэж олон жил бодож явж байсан. Энэ хуульдаа тусгасан зүйлүүд улс ингээд өөрөө хөрөнгө гаргаад ганц хоёрхон онтой байгаад байгаа юм бол тэгвэл энийг энэ нийгэм насжиж байгаа энэ үед байгууллагууд, компаниуд, хувийн хэвшил, төртэй хамтраад, эс үгүй бол хувийн хэвшил дангаараа нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ийм газруудыг байгуулбал тэрийг нь урамшуулдаг тийм ээ, үйл ажиллагааг нь төртэй хамтраад дэмждэг энэ зохицуулалтуудыг бас тусгасан байгаа.

Хот дүүргийн асуудал хэрэв одоо энэ яригдаж байгаа Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ингээд цаашаа үргэлжлээд явчихвал тэртээ тэргүй автоматаар дүүрэг гэсэн байсан газрууд хот болоод явбал түүнтэй уялдаад бүх холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт,

өөрчлөлт орж таарна. Яг тэтгэвэр, тэтгэмжтэй тэтгэврийн өвлөлт, хувийн тэтгэврийн тогтолцоо энэ тэр бол ерөнхийдөө тэтгэврийн бодлогынхоо эрх зүйн зохицуулалтынхаа ерөнхий рам хүрээ дотор яригдах нь зөв болов уу гэж бодсон. Бид нар яг өвлүүлэх энэ тэр тухай асуудал дээр энд юм байхгүй. Хувийн тэтгэврийн асуудал ч гэсэн угаасаа тэтгэвэр гэдэг том сэдэв дотроо нэгдсэн бодлого дотроо ороод шийдэгдээд явчихвал тэртээ тэргүй энэ хуулийн үйлчлэлүүдтэй давхар нөгөө талаас нь ингээд нөлөөлөөд явчихна гэсэн ийм бодлогын үүднээс хуулиудынхаа төслийг боловсруулсан. Тэгээд манайхнаас нэмж хариулт авъя гэвэл манай ажлын хэсгийнхнээс нэмж болох байх.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа сайд асуултад хариулъя.

Х.Булгантуяа: Ахмад настны тухай хуульд бид нар энэ шинэчилсэн найруулга биш нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа. Өмнө нь дутуу дулимаг хэрэгжээд байсан заалтуудыг нь ялангуяа сая энэ ахмадын сантай холбоотой асуудлыг тэгээд ганцхан төрийн байгууллага гэлтгүй хувийн хэвшил ч гэсэндээ ийм ахмадын сантай байна гэхээр Компанийн тухай хуульд хүртэл нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгаж өгсөн. Бас нэг ирэх асуулт нь энэ нь ингээд аж ахуйн нэгжүүд дээр их дарамт ирэх юм биш үү гээд 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж дээр нэг хувиар нь ойролцоогоор тооцоход нэг улсын хэмжээнд 16.5 сая төгрөг л болох юм байна.

Тэгэхээр бас тийм өндөр ачаалал бол нэгдүгээрт үүсэхгүй ээ.

Хоёрдугаарт энэ хуульд ерөөсөө бас нөгөө талдаа гол орсон нэг зүйл нь сая Нямаа Энхболд дарга бас хэллээ.

1 дүгээрт, ахмадын сангийн асуудал,

2 дугаарт, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн асуудал,

3 дугаарт, бид нарт нийтдээ асрамжийн газар улсын хэмжээнд 12 асрамжийн газарт 400 орчим ахмад настан байна. Гэхдээ энэ тоо хэрэгцээ шаардлага маш их байгаа. Жишээлбэл, 1 ТББ-ын 50 ортой энэ асрамжийн төвд 500, 600 орчим хүсэлт ирсэн байгаа. Манай Батсүмбэрт очихын тулд маш өндөр шаардлага хангадаг. Бараг нэг сургуульд тэнцэхийн дайтай л юм болдог. Заавал одоо асран хамгаалах хүнгүй гэдгээ батлах ёстой, тэтгэврийн зээлгүй байх ёстой гэх мэтчилэн. Тэгэхээр тэнд бол одоо 182 ахмад настан байна. Тэгэхээр бид нар үүнийг мөн ахмадууд маань 1 дүгээрт, ахмад настны тоо жилээс жилд нэмэгдэж байна.

2 дугаарт, дээрээс нь нэмээд хүмүүс ч гэсэндээ мөнгөө төлөөд асруулах хэрэгцээ шаардлага байна. Тэгэхээр одоо гадаадын улс оронд байдаг шиг ийм эрх зүйн орчныг бий болгоё. Зарим нь хүмүүсийнх нь хувьд өглөө очоод оройноо ирдэг зарим нь нэг дэхээс 5 дахийн хооронд байдаг, зарим нь одоо бас урт хугацаагаар асран хамгаалуулах үйлчилгээгээ авдаг. Ийм эрх зүйн орчнуудыг нээж өгөх нь манай энэ хуулийн бас гол хэрэгцээ шаардлага бас байгаад байгаа. Хувийн тэтгэврийн сангийн хуулийг бол бид нар Улсын Их Хуралд өргөн бариад жил гаруй болж байгаа.

Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ажлын хэсэг гарчихсан. Одоо зарчмын зөрүүтэй саналуудаа бүгдээрэнг нь бэлдчихсэн. Одоо Байнгын хорооны хурлаар оруулахад ер нь бэлэн болчихсон байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр энэ хуулиар бол хэрэгжих байх. 20 жилийн хувьд бол анх нийгмийн даатгалын багц хууль дээр 10 жил хамтран ажиллавал өвлүүлэхээр бид нар оруулж ирсэн. Тэгээд Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад гишүүдээс санал гарч 20 жил болж нэмэгдсэн. Тэгэхээр яах вэ,

ямар ч байсан эхний шатад хэдүүлээ хэрэгжүүлээд ингээд үзье. Тэгээд шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах байдаг юм уу. Ийм байдлаар явж болох байх гэж бодож байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлт дээр бид нар нэгдүгээрт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжиж өгье.

2 дугаарт, бид нар төрийн байгууллагуудыг ахмадын хөдөлмөр эрхлэлт дээр ганцхан дэмж гэж шахахаасаа илүүтэйгээр төр ч гэсэн өөр дээрээ бас манлайлж харуулах ёстой. Жишээлбэл, манай захын хороод, захын сумдад зарим нарийн мэргэжлийн хүмүүс олддоггүй. Жишээлбэл эмч гээд л тэгж байна. Сургуулийн эмч олддоггүй. Бараг хууль зөрчин байж тэтгэвэрт гарсан эмч авдаг.

Тэгэхээр 2 удаа ажлын байран дээр зарлаад хөдөлмөрийн насны хүн олдохгүй бол ахмад настай нэг хүнийг төрийн ажилд авах энэ хууль эрх зүйн орчныг нь бид нар бас нээж өгч байгаа юм. Энэ төрийн албаны тухай хууль дээр хориотой байгаад байсан тийм ээ.

Тэгэхээр тэтгэврийн насны хүнийг төрийн албанд авч ажиллуулахыг хориотой байгаад байсан. Энэ нь нөгөө талдаа бас Хөдөлмөрийн хуультай зөрчилтэй юм шиг харагдаад байсан. Төрийн албаны тухай хууль.

Тэгэхээр ахмад насны хууль дээр энэ өөрчлөлтийг оруулж өгснөөр манайд жишээлбэл тэтгэвэр тогтоолгосон нийт 500 мянган орчим хүн тэтгэвэр авч байгаагаас 364 мянга орчим нь ахмадууд байна. Ахмадууд маань ч гэсэндээ өнөөдөр дэлхий даяараа л тавин хэдтэй хүн 60 настай хүн гэдэг бол дэлхий даяараа одоо харьцангуй хөдөлмөрийн чадвар сайтай залуу хүн гэдэг болчихоод байгаа юм.

Тэгээд 65-тай хүн тэтгэвэрт гарахад дэлхий даяараа бараг цаана нь ахиад нэг карьер хийх нас байна гэж ярьж

байгаа юм. 65-аас 75 насны хооронд бол бүтэн цагаар өдрийн 8 цаг, 10 цаг биш юмаа гэхэд тал өдрөөр ажиллах боломжтой. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх боломжтой.

Тэгээд бид нар бараг бүх салбар дээр ялангуяа энэ эрүүл мэнд, боловсролын салбар дээр хамгийн их боломжтой юм гэж бас үзэж байгаа. Манай хүүхэд хамгааллын үйлчилгээг ч гэсэндээ бид нар энэ чиглэлийн хүмүүсийг аваад гэрээлээд ажиллуулах бас бүрэн боломжтой. Тэгэхээр одоо манай хуулиар Төрийн албаны тухай хуулиар энэ хаалттай байгаад байгаа учраас бид нар үүнийг бас нээж.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Ахмадуудаас гарч байсан нэг санал нь нөгөө асрамж сувиллыг нэг тусдаа Хөгжлийн өргөө гэдэг юм уу нөгөө нэр томъёолол дээр анхаарахгүй бол ахмадын асрамжийн газар юм уу гээд явчихаар нэрнээсээ өгсүүлээд ийм байдаг тэ? Бусад улс оронд ийм нэр байдаггүй шүү дээ. Асрамж нөгөө халамж гэдэг рүүгээ орчихно.

Тэгэхээр ийм нэр томъёон дээр бас та нар маань анхаараарай гэж хэлмээр байна. Яг түрүүн хэлж байсан Төрийн албаны тухай хуулийг хуулийн энэ чагтыг бид нар нээж өгөх ёстой Хөдөлмөрийн тухай хуулиар.

Тэгэхээр дагалдах хуулиар орж ирээд энэ өөрчлөгдөх ёстой учраас тэрийгээ бид нар бас сайн бодолцох ёстой шүү гэж хэлмээр байна.

3 дахь зүйл нь, ахмадын санг бүгд талархан дэмжиж байгаа. Тэгсэн хэрнээ энэ дүүргийн Засаг даргын Тамгын газар захиран зарцуулах эрхийг нь хороон дээрээ өгөхгүй бол нөгөө дүүрэг дээрээ өгчихөөр дүүрэг нь хорооны Засаг даргаа нөгөө нэг хурууныхаа үзүүрээр л хөдөлгөдөг шүү дээ. Бараг санхүүгийн эрх чадвар ч

байхгүй. Тэгэхээр энэ өөрөө хэрэгжихгүй болчихно ахмадын сан гээд байгаа юм. Тэгэхээр энэ захиран зарцуулах эрх дээр ч гэсэн бид нар маш тодорхой энэ хорооны Засаг даргын одоо төсөв дээр байна.

П.Анужин: Хуулийн төслийг хэлэлцэх эсэхтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн 88.9 хувь нь үзлээ.

88.9 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хурал хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг томилж байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаандаа идэвхтэй ирсэн эрхэм гишүүд та бүхэн болон ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

10.26 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.ОЮУНГЭРЭЛ